

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ...	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал.....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	12
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
5.	Илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



БИОКОМБИНАТ УТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.ЦОЛМОН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.25 № 06/592
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Биокомбинат УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Биокомбинат УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын, санхүүгийн орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, НББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Биокомбинат УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Биокомбинат УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Биокомбинат УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус улсын үйлдвэрийн газрын захирал Б.Цолмон танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Биокомбинат УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС-т нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Биокомбинат УТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 01-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн "Ихмонгол хөлөг Аудит" ХХК хэрэгжүүлэв.

Биокомбинат УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг "Ихмонгол хөлөг Аудит" ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 3/85 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Биокомбинат УТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Биокомбинат улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн зорилгыг мал, амьтны өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх зориулалт бүхий биологийн болон бусад төрлийн бэлдмэлүүдийг үйлдвэрлэж, хэрэглэгчийг чанар, стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнээр хангах, техник технологи, өрсөлдөх чадвараа ахиулах явдал гэж тодорхойлсон байна.

Биокомбинат УТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Биокомбинат УТҮГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуй нэгж байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль,
- Татварын болон нийгмийн даатгалын багц хуулиуд.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт,

холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Биокомбинат УТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Биокомбинат УТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Биокомбинат УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Биокомбинат УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

2018 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь материаллаг байдлын суурийг нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө, нийт орлогын дүнгээс тооцоход өндөр байгаа тул нийт зардлын дүнгээс тооцох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Биокомбинат УТҮГ-ын 2018 оны Нийт зардал 2,564.2 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 25.64 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь материаллаг алдаа илүү давах магадлал бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг аудитын явцад залруулж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	(Сая төгрөгөөр)
				Тайлбар
1	Зөвлөмж	2	5.5	
2	Албан шаардлага	1	17.0	
3	Төлбөрийн акт тогтоох	1	0.7	
	Дүн	4	23.2	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал-1: Шинэ жилийн арга хэмжээний зардалд шаардагдах 19.3 сая төгрөгийг цалин хөлсний бусад нэмэгдэл болгон 17.0 сая төгрөгийг олгож ажилчдаас буцаан суутган зарцуулсан байна. Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Асуудал-2: Татварын хөнгөлөлтийг буруу тооцоолсноос цалингаас 0.7 сая төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгасан. Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д" энэ хуулийн ...12.2...-т заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн тооцооллыг дахин нягталж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар 5,081.3 сая төгрөгийн анхны өртөгтэй барилга, байгууламжийг дахин үнэлсэн. Мөн 4,601.1 сая төгрөгийн ашиглах эрхтэй газрыг санхүүгийн тайланд үнэлж санхүүгийн тайланд тусгасан байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Биокомбинат УТҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,143.7 сая төгрөгийн зардлыг баталсан. Батлагдсан зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тайлант хугацаанд нийт 1,871.1 сая төгрөгийн зардал гаргаж 59,5 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Биокомбинат УТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны цахим мэдээллийн системд 18 мэдээлэл оруулахаас 18 мэдээлэл бүрэн оруулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Биокомбинат УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Биокомбинат УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Биокомбинат УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн програм хангамж

3.1.1 Илрүүлэлт:

Биокомбинат ТӨҮГ-ыг Засгийн газарын 2018 оны 188 дугаар тогтоолоор татан буулгаж, "Улсын төсөвт үйлдвэрийн газар" болгосон. Тус үйлдвэрийн газар нь жилийн эцсийн санхүүгийн тайланг төсөвт байгууллагын маягтаар тайлагнасан нь байгууллагын үйл ажиллагааны онцлогыг бүрэн тусгаж чадахгүй, бүтээгдэхүүний өртөг, зардлын объектоор бүртгэх модуль байхгүй байна. Энэ нь санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээр үнэн зөв тайлагнахгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн програмд өөрийн онцлогыг тусгасан ,өртөг зардлын тооцоог гаргах модуль суулгах асуудлыг удирдах дээд байгууллага, программ нийлүүлэгч компанид хандаж шийдвэрлүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг биелүүлж ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Кассаас нийт 5.5 сая төгрөгийн бэлэн мөнгөөр худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2017 оны Маягт заавар батлах тухай 347 дугаар тушаалын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад

борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага” гэж заасныг дагуу холбогдох баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүйгээс үргүй зардал гарах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	763,601,332.76	1,149,235,698.74
1.1.2	Дансны авлага	1,201,041,109.01	502,385,366.16
1.1.6	Бараа материал	2,351,105,690.47	2,776,063,994.46
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,571,855.00	8,755,843.42
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,324,319,987.24	4,436,440,902.78
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,446,832,254.84	9,364,836,049.30
1.2.2	Биет бус хөрөнгө		4,604,071,480.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,446,832,254.84	13,968,907,529.30
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,771,152,242.08	18,405,348,432.08
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,767,962.00	1,060,753.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,767,962.00	1,060,753.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,767,962.00	1,060,753.00
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	2,141,020,492.31	2,141,020,492.31
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,467,293,059.28	7,477,130,741.70
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		6,068,361,539.28
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,159,070,728.49	2,717,774,905.79
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,767,384,280.08	18,404,287,679.08
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	7,771,152,242.08	18,405,348,432.08

4.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	1,122,861,119.96
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	717,188,328.06
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	206,993,237.29
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	1,639,975,377.31
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	(1,441,295,822.70)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	(1,441,295,822.70)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	2,259,619,642.98
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	1,834,056,277.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	522,507,966.15
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	45,492,068.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	159,103,594.58
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	374,357,402.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	33,817,426.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	698,777,820.27
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	425,563,365.98
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	39,929,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	39,929,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	385,634,365.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	763,601,332.76
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,149,235,698.74

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриятлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	-
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,141,020,492.31	-	1,467,293,059.28	4,159,070,728.49	7,767,384,280.08
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,441,295,822.70)	(1,441,295,822.70)
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	4,601,068,480.00	-	4,601,068,480.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	7,477,130,741.70	-	-	7,477,130,741.70
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,141,020,492.31	7,477,130,741.70	6,068,361,539.28	2,717,774,905.79	18,404,287,679.08

4.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,143,729,248.76	1,871,112,218.00	-1,272,617,030.76	59.52%
УРСГАЛ ЗАРДАЛ	3,143,729,248.76	1,871,112,218.00	-1,272,617,030.76	59.52%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,124,205,328.76	1,851,588,298.00	-1,272,617,030.76	59.27%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	877,589,699.18	520,874,907.15	356,714,792.03	59.35%
Үндсэн цалин	877,589,699.18	520,874,907.15	-356,714,792.03	59.35%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,492,068.00	45,492,068.00	-	100.00%
Тэтгэврийн даатгал	45,492,068.00	45,492,068.00	-	100.00%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	416,742,919.00	374,357,402.00	-42,385,517.00	89.83%
Гэрэл, цахилгаан	119,341,519.00	77,357,402.00	-41,984,117.00	64.82%
Түлш, халаалт	297,000,000.00	297,000,000.00	-	100.00%
Цэвэр, бохир ус	401,400.00	-	-401,400.00	0.00%
Хангамж, бараа материалын зардал	344,604,625.58	162,353,594.58	-182,251,031.00	47.11%
Бичиг хэрэг	83,353,700.00	1,992,250.00	-81,361,450.00	2.39%
Тээвэр, шатахуун	37,969,120.00	33,817,426.00	-4,151,694.00	89.07%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,073,835.58	1,073,835.58	-1,000,000.00	51.78%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000.00	10,000.00	-	100.00%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	217,000,910.00	123,232,593.00	-93,768,317.00	56.79%
Аж ахуйн материал худалдан авах зардал	4,197,060.00	2,227,490.00	-1,969,570.00	53.07%
Нормативт зардал	584,010,435.00	515,199,207.20	-68,811,227.80	88.22%
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	484,610,435.00	478,589,207.20	-6,021,227.80	98.76%
Хоол, хүнс	36,610,000.00	36,610,000.00	-	100.00%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	62,790,000.00	-	-62,790,000.00	0.00%
Эд хогшил, урсгал засварын зардал	772,243,326.00	181,508,389.00	590,734,937.00	23.50%
Багаж, техник, хэрэгсэл	47,924,225.00	47,602,000.00	322,225.00	99.33%
Тавилга	18,862,200.00	18,862,200.00	-	100.00%
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,526,000.00	2,525,900.00	-100.00	100.00%
Урсгал засвар	702,930,901.00	112,518,289.00	-590,412,612.00	16.01%
Томилолт, зочны зардал	10,917,720.00	7,077,100.00	-3,840,620.00	64.82%
Гадаад албан томилолт	6,000,000.00	5,096,900.00	-903,100.00	84.95%
Дотоод албан томилолт	4,917,720.00	1,980,200.00	-2,937,520.00	40.27%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,992,267.00	42,197,030.07	-13,795,236.93	75.36%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,174,000.00	30,846,398.07	-7,327,601.93	80.80%

Тээврийн хэрэгслийн татвар	414,500.00	414,500.00	-	100.00%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,196,000.00	4,585,000.00	-4,611,000.00	49.86%
Газрын төлбөр	5,941,232.00	5,941,232.00	-	100.00%
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,266,535.00	409,900.00	-1,856,635.00	18.08%
Бараа үйлчилгээний бусад зардал	16,612,269.00	2,528,600.00	14,083,669.00	15.22%
Бараа үйлчилгээний бусад зардал	16,612,269.00	2,528,600.00	14,083,669.00	15.22%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,523,920.00	19,523,920.00	-	100.00%
Бусад урсгал шилжүүлэг	19,523,920.00	19,523,920.00	-	100.00%
Ажил олгогчоос олгохбусад тэтгэмж, урамшуулал	19,523,920.00	19,523,920.00	-	100.00%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	763,601,332.76	2,254,931,177.90	1,491,329,845.14	295.30%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	763,601,332.76	2,254,931,177.90	1,491,329,845.14	295.30%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,241,398,010.90	2,241,398,010.90	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	13,533,167.00	13,533,167.00	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	763,601,332.76	-	-763,601,332.76	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	763,601,332.76	763,601,332.76	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,149,235,698.74	1,149,235,698.74	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00	57,281.00	
Удирдах ажилтан	555.00	7,878.00	7,323.00	
Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00	4,090.00	
Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00	45,868.00	

5. Илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Огноо: 2019.03.06	Аудитын нэр: 2018 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшинд хийсэн аудитын тайлан	Аудитын код: САГ-2019/65/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Биокомбинат УТҮГ	Сая төгрөгөөр	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Шинэ жилийн арга хэмжээний зардалд шаардагдах 19.3 сая төгрөгийг цалин хөлсний бусад нэмэгдлээр олгож 17.001 сая төгрөгийг шинэ жилийн арга хэмжээнд ажилчдаас суутган зарцуулсан байна. Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.	17.0	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Б.Цолмон Ц.Жавзандулам
Татварын хөнгөлөлтийг буруу тооцооллосноос цалингаас 0.74 сая төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгасан. Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д" энэ хуулийн ...12.2...-т заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасныг зөрчсөн.	0.7	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Б.Цолмон Ц.Жавзандулам
Биокомбинат ТӨҮГ-ыг Засгийн газарын 2018 оны 188 дугаар тогтоолоор татан буулгаж, "Улсын төсөвт үйлдвэрийн газар" болгосон. Тус үйлдвэрийн газар нь жилийн		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Цолмон Ц.Жавзандулам

<p>эцсийн санхүүгийн тайланг төсөвт байгууллагын мяггаар тайлагнасан нь байгууллагын үйл ажиллагааны онцлогыг бүрэн тусгаж чадахгүй, бүтээгдэхүүний өртөг, зардлын объектоор бүртгэх модуль байхгүй байна. Энэ нь санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.</p>				
<p>Кассаас нийт 5.5 сая төгрөгийн бэлэн мөнгөөр худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2017 оны Маягт заавар батлах тухай 347 дугаар тушаалын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага" гэж заасныг дагуу холбогдох баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.</p>	5.5	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Цолмон Ц.Жавзандула М
Нийт дүн	23.2			

